



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

2024.07.25 № 1а/3042
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Д.АМАРБАЯСГАЛАН,
САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН,
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ЗАГДЖАВ ТАНАА

2025 оны төсвийн төсөл,
2026-2027 оны төсвийн
төсөөллийн санал хүргүүлэх
тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын дагуу Эрүүл мэндийн сайдын багцын болон Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн саналыг боловсруулан танилцуулгын хамт хүргүүлж байна.

Төсвийн саналыг эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг сайжруулах, Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн багц хуулиуд, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Төсвийн удирдамж хүргүүлэх тухай" 01/5374 дугаар албан бичиг болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн дагуу боловсруулав.

Хавсралт ... хуудас

Хүндэтгэсэн,



Т.МӨНХСАЙХАН

141425179



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН БАРИМТ БИЧИГ

Танилцуулга

Улаанбаатар

2024 он

АГУУЛГА

Нэг. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд баримтлах үндсэн бодлого

- 1.1 “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”
- 1.2 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- 1.3 Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- 1.4 Эрүүл мэндийн салбарын нийт зардал ба ДНБ

Хоёр. Салбарын 2025 оны төсвийн онцлох арга хэмжээ, зориултууд

Гурав. Эрүүл мэндийн сайдын 2025 оны төсвийн төслийн товч танилцуулга

- 3.1 Эрүүл мэндийн сайдын багцын 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл
- 3.2 Эрүүл мэндийн сайдын багцын 2025 оны төсвийн төсөл
- 3.3 Эрүүл мэндийн сайдын багцын 2026, 2027 оны төсвийн төсөөлөл

Дөрөв. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төслийг боловсруулахад баримтлсан зарчим

- 4.1 Хууль эрх зүйн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал
 - 4.1.1 2025 онд баримтлах төсвийн бодлого
 - 4.1.2 Эрүүл мэндийн даатгалын орлого тооцолтын шимтгэлийн хувь
 - 4.1.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тооцооллын зарчим
- 4.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл
- 4.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөл
 - 4.3.1 Сангийн 2025 оны төсвийн тэнцэл
 - 4.3.2 Сангийн орлого
 - 4.3.3 Сангийн зарлага
- 4.4 Үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй
 - 4.4.1 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардал
 - 4.4.2 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардал
- 4.5 2026 оны төсвийн төсөөлөл

Тав. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт

- 5.1 Нийт хөрөнгө оруулалт
- 5.2 Барилга байгууламж
- 5.3 Тоног төхөөрөмж
- 5.4 Их засвар

Зургаа. Төсвийн тухай хуулийн хавсралт

- 6.1 Эрүүл мэндийн сайдын багцын төсөв
- 6.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв
- 6.3 Төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтад орох мэдээлэл

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН САНХҮҮЖИЛТЭД БАРИМТЛАХ ҮНДСЭН БОДЛОГО

1.1. “Тогтвортой хөгжил – 2030 хөтөлбөр”



Тогтвортой хөгжлийн зорилтын “Эрүүл мэндийг дэмжих” 3 дах зорилгын 13 зорилт, 27 үзүүлэлт болон шалгуурыг хангах зорилгоор төсвийн төслийг боловсруулсан болно.

1.2. “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Зорилт 2.2. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.

- ✓ Иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо бэхэжсэн байна.
- ✓ Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна.
- ✓ Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдсэн байна.
- ✓ Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулсан байна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйл буурсан байна.
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, нийт сумыг хамарсан алсын зайн үндэсний сүлжээг бий болгож, хүн амын дундаж наслалт уртассан байна.
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, зүрх, судасны өвчлөлөөс болон хорт хавдраас шалтгаалсан нас баралт буурсан байна.
- ✓ Төвлөлт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, вируст гепатитын өвчлөл, сүрьеэгийн тохиолдлыг бууруулсан байна.
- ✓ Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буурсан байна.

1.3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Зорилт 2.2. Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл

хийнэ:

2.2.1.Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.

2.2.2.Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.

2.2.3.Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.

2.2.4.Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.

2.2.5.Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна.

2.2.6.Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.

2.2.7.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.


2.2.8.Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.

1.4. Эрүүл мэндийн салбарын нийт зардал ба Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/

2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлээр эрүүл мэндийн салбарт зарцуулсан зардал ДНБ-д 2.9 хувийг эзэлж байна.

Зураг 1. ДНБ-д эзлэх эрүүл мэндийн салбарын төсвийн хувь хэмжээ /тэрбум.төг/

Санхүүжих эх үүсвэр	Батлагдсан төсөв		ХБГ	2025 хязгаар	2025 ТЕЗ санал	Зөрүү
	2023 он	2024 он				
Эрүүл мэндийн даатгал сан	1,518.5	1,933.2	2,151.5	1,971.3	2,881.7	948.5
Улсын төсөв	224.2	282.4	289.7	217.1	512.8	230.4
Хөрөнгө оруулалт	172.1	281.1	281.1	145.5	993.4	712.3
Эрүүл мэндийн салбарын нийт төсөв	1,914.8	2,496.7	2,722.3	2,333.9	4,387.9	1,891.2



Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу хөгжиж буй орон дотоодын нийт бүтээгдэхүүний 5-аас доошгүй хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулснаар эрүүл мэндийн салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлээр суурь нөхцлүүд бүрдэнэ гэж зөвлөдөг. 2025 онд эрүүл мэндийн салбарт зарцуулах нийт хөрөнгийг ДНБ-ний 4.4% байхаар тооцож төлөвлөсөн.

ХОЁР: САЛБАРЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ, ЗОРИЛТУУД:

✓ Тогтвортой хөгжлийн эрүүл мэндийн зорилт арга хэмжээний хүрэх шалгуур үзүүлэлтийг дээшлүүлж бүх нийтийн хамралтын хувийг дээшлүүлнэ.

Эрүүл мэндийн гол анхаарах асуудал болох эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн эрсдлийг бууруулах, гадаад орон руу очиж эмчлүүлж буй санхүүгийн урсгалыг бууруулах зэрэг зарим арга хэмжээг төсвийн саналд тусгасан.

✓ Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцооны үр дүнг нэмэгдүүлнэ.

Эрүүл мэндийн салбарт чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан “иргэнээ дагасан” санхүүжилтийн тогтолцоог 2021 оноос хэрэгжүүлсэн ба гүйцэтгэлийн санхүүжилтийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, шаардлагатай бодлогын тохируулгуудыг хийж

ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолоор оношийн хамааралтай бүлгийн журам, жагсаалтыг шинэчлэн баталж, зарим бодлогын тохируулгыг 2025 онд хэрэгжүүлэхээр зохицуулсаныг тусгаж, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцлийг хангаж нэмэгдүүлэн төсвийн саналд тусгасан.

✓ Анхан шатлалын тусламж, үйлчилгээг бэхжүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэх, иргэнээ дагасан санхүүжилтэд хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05 дугаар тогтоолоор “Нэг иргэнд тооцох” санхүүжилтийн аргын суурь тарифыг тухайн орон нутгийн хүн амын нягтаршил, алслалтын байдлаас шалтгаалсан тэгш байдлын тохируулга хийж, Засгийн газраас шинэчлэн баталсан 2024 оны 82, 128 дугаар тогтоолын дагуу нэмэгдэх цалингийн сангийн өсөлтийн тохируулга хийж тусгасан. Мөн анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг өргөжүүлэн шинэчилж Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/283 дугаар тушаалаар баталсантай холбоотой тооцоололуудыг тусгасан.

✓ Эрүүл мэндийн байгууллагуудыг хөгжүүлэх хөгжлийн стратеги төлөвлөгөөнд үндэслэн нэгж байгууллагын үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. (ISO)

Эрүүл мэндийн байгууллагуудын үйлчилгээний менежментийг сайжруулах, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлуудыг тусгасан. (Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг шинэчилж, жишиг тарифт өөрчлөлт оруулахтай холбоотой зардал, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналт хийх журмыг шинэчилж, хөндлөнгийн эмнэлзүйн шинжээч нарыг гэрээгээр ажиллуулах, техникийн хороог Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэд ажиллуулах г.м)

✓ Шинэ болон дахин сэргэж буй халдварын эрсдлээс сэргийлэх, хамгаалах, бэлэн байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

✓ Эмнэлгийн хагас бие даасан байдлыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагын удирдлагын менежментийг сайжруулж нөөцийн зөв хуваарилалт, зарлагын үр ашгийг нэмэгдүүлнэ.

✓ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлж өртөг зардлыг тооцох, хөтөлбөр төсөл арга хэмжээг санхүүжүүлэх аргачлалыг батлуулна.

“Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль” батлагдсантай холбоотойгоор үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дагуу тооцож 2025 оны төсвийн төсөлд тусгасан.

✓ Эм, эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн худалдан авалтын үйл ажиллагааг дэмжих замаар үнийн бодлогыг хэрэгжүүлж, эмийн чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

“Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль” батлагдсаны дагуу эмийн чанар, аюулгүй байдлыг шинжлэх лабораторийн зардлыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын төсөвт тус тус тусгасан.

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1. Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Эрүүл мэндийн сайдын багцын 2023 оны гүйцэтгэл 1,326.8 тэрбум төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 1,860.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд тухайн оны батлагдсан төсвөөс 225.7 тэрбум төгрөг хэтрэхээр хүлээгдэж байгаа бөгөөд эрүүл мэндийн даатгалын санд 2023 оны жилийн эцэст 218.3 тэрбум төгрөгийн өр төлбөр үүссэнтэй холбоотой байна. Иймд 2024 оны тодотголын саналд 218.3 тэрбум төгрөгийг нэмж тусгуулахар санал хүргүүлсэн. Мөн 7.4 тэрбум төгрөгийн төсвийн зарлагын хэтрэлтийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу шийдвэрлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн сайдын багцын 2023 оны гүйцэтгэл болон 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, эдийн засгийн ангиллаар /мян.төгрөг/

Код	Зардлын эх үүсвэр	ГҮЙЦЭТГЭЛ		ӨӨРЧЛӨЛТ
		2023 Гүйц	2024 ХБГ	2023 гүйц 2024 ХБГ
1		2	3	4
А. ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗҮЙЛС				
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	64,739,044.5	91,909,945.6	41.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,493,177.8	11,636,544.2	37.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,953,919.2	3,772,178.6	27.70
2104	Хангамж, бараа материалын зардал	1,601,289.4	2,016,373.9	25.92
2105	Нормативт зардал	21,598,336.6	35,314,271.3	63.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,637,780.9	3,600,009.1	(22.38)
2107	Томилолт, зочны зардал	694,692.7	1,750,278.1	151.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,077,718.2	9,727,744.8	216.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,704,392.3	60,352,339.0	(10.86)
212	Засгийн газрын урсгал шилжүүлэг	939,570,876.6	1,289,320,743.1	37.22
213	Бусад урсгал шилжүүлэг	44,949,956.8	69,588,260.6	54.81
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	166,753,934.4	281,078,998.2	68.56
НИЙТ, ЗАРДЛЫН ЗҮЙЛ АНГИ		1,326,775,119.4	1,860,067,686.5	40.19

Хүснэгт 2. Эрүүл мэндийн сайдын багцын 2023 оны гүйцэтгэл болон 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, зардлын зориулалт арга хэмжээгээр

/мян.төгрөг/

Код 1	Зардлын эх үүсвэр	ГҮЙЦЭТГЭЛ		ӨӨРЧЛӨЛТ
		2023 Гүйц 2	2024 ХБГ 3	2023 гүйц 2024 ХБГ 4
Б. ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ-АРГА ХЭМЖЭЭ				
801000	үйл ажиллагааны урсгал зардлын ерөнхий зориулалт	134,106,747.1	100,367,447.7	(25.2)
802000	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	789,654.0	1,225,995.9	55.3
803000	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	149,115.1	0.0	(100.0)
805000	Засгийн газрын дотоод болон гадаад шилжүүлгийн зориулалт	65,499.7	81,310.2	24.1
807000	Нийгмийн халамжийн шилжүүлгийн зориулалт	800,300.0	955,494.0	19.4
808000	Бусад шилжүүлгийн зориулалт	296,209,738.4	392,745,733.0	32.6
808080	Орон байраар хангах, орон сууцны дэмжлэг (хувь хүмүүст олгох)	0.0	0.0	-
808090	Эмчилгээний төлбөр	795,834.4	4,000,000.0	402.6
809000	Хөрөнгийн зардлын зориулалт	166,753,934.4	281,078,998.2	68.6
813000	Нөөц хөрөнгийн зориулалт	0.0	2,943,000.0	-
815000	Төрийн нийтлэг арга хэмжээ	167,291.7	4,663,115.0	2,687.4
816000	Эрүүл мэндийн арга хэмжээ	727,222,064.6	1,071,107,795.5	47.3
817000	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	84,779.9	2,293,359.2	2,605.1
818000	Боловсролын арга хэмжээ	0.0	2,000,000.0	-
821000	Биеийн тамир, спортын арга хэмжээ	0.0	0.0	-
831000	Эдийн засгийн бусад	425,994.5	605,437.8	42.1
НИЙТ, ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ-АРГА ХЭМЖЭЭ		1,326,775,119.4	1,860,067,686.5	40.2

2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг 2023 оны гүйцэтгэлтэй харьцуулахад **40.2** хувиар нэмэгдэж байгаа нь 2024 оны 04 сарын 01-ээс төрийн албан хаагчдын цалин, хөлсийг нэмэгдүүлсэн, мөн 2023 оны эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өр төлбөртэй холбоотой байна.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн сайдын багцын 2023 оны гүйцэтгэл болон 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, зардлын эх үүсвэрээр

/мян.төгрөг/

Код	Зардлын эх үүсвэр	ГҮЙЦЭТГЭЛ		ӨӨРЧЛӨЛТ
		2023 Гүйц	2024 ХБГ	2023 гүйц 2024 ХБГ
1		2	3	4.0
В. САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
31	Улсын төсвөөс санхүүжих	1,319,819,105.6	1,853,196,757.7	40.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,319,819,105.6	1,853,196,757.7	40.4
35	Төсөвт байгууллагын өөрийн орлогоос санхүүжих	6,956,013.8	6,870,928.8	(1.2)
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,536,924.4	6,736,924.3	3.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	419,089.4	134,004.5	(68.0)
НИЙТ		1,326,775,119.4	1,860,067,686.5	40.2

3.2. Эрүүл мэндийн сайдын багцын 2025 оны төсвийн санал

Хүснэгт 4. Эрүүл мэндийн сайдын багцын 2025 оны хязгаарын дүн болон 2025 оны төсвийн төсөл, эдийн засгийн ангилалаар /мян.төгрөг/

Код	ЗАРДЛЫН ЗҮЙЛ АНГИ	САНАЛ		ӨӨРЧЛӨЛТ
		2025 Хяз	2025 ТЕЗ санал	2025 хяз 2025 сан
1		2	3	4
А. ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗҮЙЛС				
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	91,290,898.5	134,254,895.5	47.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,525,361.5	17,165,469.6	48.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,745,054.7	4,987,820.5	33.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,839,233.8	2,526,535.6	37.4
2105	Нормативт зардал	34,035,498.9	45,651,242.8	34.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,636,177.3	3,727,361.3	41.4
2107	Томилолт, зочны зардал	1,126,609.6	2,396,498.3	112.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,211,028.2	58,353,998.2	1,019.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,394,516.2	160,500,615.6	153.2
212	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,074,794,499.0	1,825,647,210.2	69.9
213	Бусад урсгал шилжүүлэг	2,203,512.3	83,190,570.3	3,675.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	145,534,801.4	993,415,615.0	582.6
НИЙТ, ЗАРДЛЫН ЗҮЙЛ АНГИ		1,437,337,191.4	3,331,817,832.9	131.8

Эдийн засгийн ангиллаар авч үзэхэд инфляцийн түвшинээс шалтгаалан “Хангамж, бараа материалын зардал”, “Норматив зардал” “Томилолт зочны зардал” “Эд хогшил урсгал засварын зардал” зэргийг нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 2024 онд бууруулан баталсан зарим зардлыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн тул шаардлагатай зардлыг нэмэгдүүлж төлөвлөсөн. Мөн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль шинээр батлагдсантай холбоотойгоор “Бараа ажил үйлчилгээний бусад зардал”, “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал”-ыг тус тус нэмэгдүүлэн төсөвлөсөн.

Хүснэгт 5. Эрүүл мэндийн сайдын багцын 2025 оны хязгаарын дүн болон 2025 оны төсвийн төсөл, зориулалт арга хэмжээгээр

/мян.төгрөг/

Код	ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ-АРГА ХЭМЖЭЭ	САНАЛ		ӨӨРЧЛӨЛТ
		2025 Хяз	2025 ТЕЗ санал	2025 хяз 2025 сан
1		2	3	4
Б. ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ-АРГА ХЭМЖЭЭ				
801000	үйл ажиллагааны урсгал зардлын ерөнхий зориулалт	94,001,827.3	169,183,026.3	80.0
802000	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	1,061,541.8	1,235,875.3	16.4
803000	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	0.0	381,112.4	
805000	Засгийн газрын дотоод болон гадаад шилжүүлгийн зориулалт	81,310.2	81,310.2	-
807000	Нийгмийн халамжийн шилжүүлгийн зориулалт	955,494.0	955,494.0	-
808000	Бусад шилжүүлгийн зориулалт	325,360,984.7	788,308,476.3	142.3
809000	Хөрөнгийн зардлын зориулалт	145,534,801.4	993,415,615.0	582.6
813000	Нөөц хөрөнгийн зориулалт	2,943,000.0	34,061,000.0	1,057.4
815000	Төрийн нийтлэг арга хэмжээ	2,998,615.0	22,043,308.8	635.1
816000	Эрүүл мэндийн арга хэмжээ	861,540,627.8	1,308,648,684.6	51.9
817000	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	2,293,359.2	2,438,300.0	6.3
818000	Боловсролын арга хэмжээ	0.0	3,000,000.0	
821000	Биеийн тамир, спортын арга хэмжээ	0.0	7,500,000.0	
831000	Эдийн засгийн бусад	565,630.0	565,630.0	-
НИЙТ, ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ-АРГА ХЭМЖЭЭ		1,437,337,191.4	3,331,817,832.9	131.8

Эрүүл мэндийн сайдын багцын 2025 оны төсвийн төслийн саналыг 2025 оны хязгаараас **1,894.5 тэрбум төгрөгөөр** нэмэгдүүлсэн бөгөөд нийт нэмэгдлийн **44.8%** нь хөрөнгө оруулалтын зардал, **40.0%** нь төр хариуцах тусламж, үйлчилгээний зардал, **15.2%** нь эрүүл мэндийн сайдын багцын урсгал үйл ажиллагааны зардлын нэмэгдэл байна.

Урсгал үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлсэн томоохон арга хэмжээнүүд

Цалин, хөлсний зардал:

Засгийн газрын 2024 оны 12, 82, 83, 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор эрүүл мэндийн салбарын байгууллагуудын цалингийн зардлыг нэмэгдүүлэн төлөвлөсөн.

Мөн Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, зоонозын өвчин судлалын төвийг түшиглэн 1165 орон тоог шинээр бий болгоход шаардлагатай 28.0 тэрбум төгрөгийг нэмж төсөвлөжээ.

Нормативт зардал:

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Хүүхдийн төв сувилал, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын үйл ажиллагааны орлогыг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2022 оны 49/А/118 дугаар тушаалын хүрээнд 2.5 тэрбум төгрөгөөр төсөвлөлөө.

Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал:

Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу 2025 онд тэтгэвэрт гарах 1099 хүний 35.7 тэрбум төгрөг, хөдөө, орон нутаг тогтвор суурьшилтай ажиллаж буй ажилтны тэтгэмжид 3385 хүний 27.6 тэрбум төгрөг, Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023 оны 68 дугаар тогтоолын 5 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах, орон нутагт хомсдолтой байгаа эмч, багийн эмч, сувилагчийн орон тооны хангалт хийж 500 албан хаагчийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 10.0 тэрбум төгрөгийг төсөвлөсөн.

Эмч, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын зардал:

Монгол улсын эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугаар Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургах тухай “Журам батлах, зардлын жишиг төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тушаалыг шинэчлэх ажлын хүрээнд хичээл үйлдвэрлэлийн зардлыг 4.0 тэрбум төгрөгийг нэмж төсөвлөсөн.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль батлагдсантай холбоотой нэмж шаардагдах зардал:

“Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль” 2024 онд батлагдсан. Хууль батлагдсанаар үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дагуу тооцож 2025 оны төсвийн төсөлд тусгасан. Тус зардлыг төлөвлөхдөө Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хүн амын эрүүл мэнд, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, үнэлэх, хариу арга хэмжээг авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахтай холбоотойгоор дараах арга хэмжээгээр төлөвлөсөн. Үүнд:

- Улсын хэмжээнд 12 үндэсний төвийн тандалт, судалгааны нэгжийн чадавхийг бэхжүүлэх,
- Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, зоонозын өвчин судлалын төвийг түшиглэн нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах,
- Нийгмийн эрүүл мэндийн бодлого, удирдлагыг хэрэгжүүлэх,
- Эрүүл мэндийн боловсрол олгоход зэрэгт нийт 102.1 тэрбум төгрөгийн саналыг нэмж

төсөвлөсөн.

Тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх:

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 20.7 дахь хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1.5.ж-дэх заалтын дагуу Эрүүл мэндийн сайд, Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын 2023 оны а/125/80 дугаарын хамтарсан тушаалаар батлагдсан “хамгаалуулагчийн эрүүл мэндийг хамгаалах талаар төрийн тусгай хамгаалалтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага хамтран ажиллах журам”-ыг хэрэгжүүлэхэд 18 орон тоотойгоор 6 ортой өрөө болон амбулаторийн 4 кабинетад тусламж үйлчилгээ үзүүлдэг. Мөн гадны зочид төлөөлөгч болон гэрийн тогтмол үзлэгийг хийж, Төрийн гурван өндөрлөгийг гадаад, дотоод томилолтоор явахад баг бүрэлдэхүүнд орж дагалдан явдаг. Тус эмнэлгийн хувьд 2021 оноос гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд бүрэн нэвтэрсэн хэдий ч тусгай чиг үүргийн үйл ажиллагааны зардал нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжихээр зохицуулагдаагүй байна. Иймд 2025 онд Улсын их хурлын 126 гишүүн болон гадны зочид төлөөлөгчдөд тусламж үйлчилгээ үзүүлэхэд холбогдон гарах зардлыг 2.6 тэрбум төгрөгөөр төсөвлөв.

Эм, шинжлэлийн лабораторийн чадавхийг сайжруулах:

Монгол улсын хэмжээнд хэрэглэгдэж буй эмийн чанар аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийг чанартай, баталгаатай эмээр хангах зорилгоор импортын болон дотоодын үйлдвэрийн эмэнд чанарын хяналт хийх, чадавхи бүхий нэгжийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын бүтцэд бий болгосон бөгөөд лабораторийн чадавхийг сайжруулах, хангажийг нэмэгдүүлэх зорилгоор шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлэхэд шинээр 22 орон тооны, цалингийн зардал, лабораторийн эм, урвалж, оношлуур, зарим тоног төхөөрөмжийн зардлын хамт нийт 2.4 тэрбум төгрөгийг урсгал төсөвт тусгасан ба үндсэн үйл ажиллагааны орлогыг 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр төсөвлөлөө.

Цахим бодлогыг дэмжих:

Төрийн болон албаны нууцын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.5, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 207 дугаар тогтоолд заасны дагуу “Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт”-д багтсан Эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглаж байгаа сервер тоног төхөөрөмж, сүлжээний тоног төхөөрөмжийг шинэчлэх, мэдээлэл сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, судалгаа төлөвлөлтийг сайжруулах, эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформыг хөгжүүлж эрүүл мэндийн байгууллагууд хооронд мэдээллийг нэг стандартаар саадгүй солилцох үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтвортой үйл ажиллагааг хариуцан ажиллана.

Геронтологийн үндэсний төвийн шинэ барилга ашиглалтад орохтой холбоотой нэмж шаардагдах зардал:

Геронтологийн үндэсний төвийн 6 давхар барилга 60 ортой хэвтэн эмчлүүлэх тасаг бүхий 3077.54 мкв талбайтай шинэ барилга 2024 оны 3 дугаар улиралд ашиглалтанд орж байна. Шинэ барилга ашиглалтад орж буйтай холбоотойгоор 51 орон тоо шинээр нэмэгдэхээс улсын төсвөөс санхүүжих орон тоо нь 35 байна. Иймд Геронтологийн үндэсний төвийн төсвийг 1.3 тэрбум төгрөгөөр нэмж төсөвлөлөө.

Эрүүл мэндийн салбарын эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлэх:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.3.5 ба 10.4.5 заалтыг тус тус үндлэслэн болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн салбарын нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодисын жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 тушаалаар баталсан бөгөөд нөөц бүрдүүлэх зардлыг 31,1 тэрбум төгрөгийг нэмж төсөвлөсөн.

Эрүүл мэндийн сайдын багцын 2025 оны төсвийн төслийн саналыг байгууллагаар задлан харуулбал:

Хүснэгт 6. Эрүүл мэндийн сайдын багцын 2025 оны хязгаарын дүн болон 2025 оны төсвийн төсөл, төсвийн захирагчаар /мян.төгрөг/

Код	Эдийн засгийн ангилал	САНАЛ		ӨӨРЧЛӨЛТ
		2025 Хяз	2025 ТЕЗ санал	2025 хяз 2025 сан
1	2	3	4	5
1	Эрүүл мэндийн газар	29,625,572.3	75,939,171.4	156.3
2	Зоонозын өвчин судлалын төв	15,159,208.1	17,744,976.0	17.1
3	Нийслэлийн эрүүл мэндийн газар	4,188,657.9	17,289,556.3	312.8
4	Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, их засвар	145,534,801.4	993,415,615.0	582.6
5	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	8,490,888.3	11,677,394.7	37.5
6	Эмгэг судлалын үндэсний төв	2,893,585.6	3,453,188.3	19.3
7	Хүүхдийн төв сувилал	3,865,716.6	4,684,827.7	21.2
8	Эрүүл мэндийн яам	8,924,143.4	9,910,129.9	11.0
9	Эрүүл мэндийг дэмжих сан	9,810,000.0	15,826,000.0	61.3
10	Геронтологийн төв	1,859,279.0	5,645,803.1	203.7
11	Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв	1,175,503.1	1,971,249.2	67.7
12	Шүд Эрүү Нүүрний төв	1,238,807.0	1,409,857.9	13.8
13	Энэрэл эмнэлэг	2,067,331.7	2,988,233.2	44.5
14	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	4,600,394.8	5,044,182.1	9.6
15	Эрүүл мэндийн хөгжлийн төв	36,251,730.5	38,782,413.5	7.0
16	4-р сувилалын ясли /УБ-ХУД/	1,453,769.0	1,952,257.6	34.3
17	40-р сувилалын ясли /УБ-БЗД/	1,480,317.5	2,281,498.3	54.1
18	41-р сувилалын ясли /УБ-СХД/	1,293,795.2	1,555,345.6	20.2
19	Эмийн зохицуулалтын агентлаг	6,074,215.5	8,079,680.5	33.0
20	Улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээн	1,151,349,474.5	2,112,166,452.6	83.5
НИЙТ		1,437,337,191.4	3,331,817,832.9	131.8

Харъяа эрүүл мэндийн байгууллагуудаас үндсэн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх боломжтой Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Хүүхдийн төв сувилалын 2025 оны төсвийн зарлагыг орлогын хэмжээгээр нэмэгдүүлсэн.

3.3. Эрүүл мэндийн сайдын багцын 2026, 2027 оны төсвийн төсөөлөл

Хүснэгт 7. Эрүүл мэндийн сайдын багцын 2026, 2027 оны төсвийн төсөөлөл, зориулалт арга хэмжээгээр /мян.төгрөг/

Код	ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ-АРГА ХЭМЖЭЭ	ТӨСӨӨЛӨЛ	
		2026	2027
		төсөөлөл	төсөөлөл
1	2	3	4
Б. ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ-АРГА ХЭМЖЭЭ			
801000	үйл ажиллагааны урсгал зардлын ерөнхий зориулалт	211,553,345.1	223,461,764.3
802000	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	1,578,336.0	1,662,274.2
803000	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	0.0	0.0
805000	Засгийн газрын дотоод болон гадаад шилжүүлгийн зориулалт	85,907.7	94,498.6
807000	Нийгмийн халамжийн шилжүүлгийн зориулалт	955,494.0	1,089,000.0
808000	Бусад шилжүүлгийн зориулалт	809,970,531.7	810,697,000.9
809000	Хөрөнгийн зардлын зориулалт	1,150,800,000.0	1,054,600,000.0
813000	Нөөц хөрөнгийн зориулалт	34,061,000.0	34,061,000.0
815000	Төрийн нийтлэг арга хэмжээ	22,081,189.7	22,122,858.6
816000	Эрүүл мэндийн арга хэмжээ	1,310,601,384.6	1,288,460,282.6
817000	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	2,438,300.0	2,438,300.0
818000	Боловсролын арга хэмжээ	3,000,000.0	3,000,000.0
821000	Биеийн тамир, спортын арга хэмжээ	7,500,000.0	7,500,000.0
831000	Эдийн засгийн бусад	903,816.4	912,742.0
НИЙТ, ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ-АРГА ХЭМЖЭЭ		3,555,529,305.2	3,450,099,721.2

Төсвийн төсөөллийг инфляцийн дундаж түвшинтэй уялдуулан жил бүр 10 хувиар нэмэгдүүлэн тооцсон.

Аймаг, дүүрэг, сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тогтмол зардал:

Эрүүл мэндийн салбар гүйцэтгэл, чанар үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд бүрэн шилжиж эрүүл мэндийн байгууллагууд үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байна. Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийн шинэчлэл тухайн орон нутгийн хүн амын тоо, газар зүйн байршил, барилга б

айгууламжийн хэмжээ, орон нутгийн онцлогоос хамаарч харилцан адилгүй хэрэгжиж байна.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.18-д “...төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар нь орон нутгийн чиг үүрэгт хамаарна”, мөн тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т “Чиг үүрэг хэрэгжүүлэх санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэдэг байх” гэж тус тус заасны дагуу 2024 оны төсвийн жилээс аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, уламжлалт анагаах ухааны төвийн байр ашиглалтын тогтмол зардлыг тухайн орон нутаг нь хариуцахаар орон нутгийн төсвөөс санхүүжүүлж эхлээд байна. 2025 оны төсвийн жилд байр ашиглалтын тогтмол зардлыг тухайн орон нутагт бүрэн хариуцуулах, мөн дүүргийн

эрүүл мэндийн төв, амаржих газар, аддиктологийн төв, нийслэлийн шүд, эрүү нүүрний төв, энэрэл эмнэлгийн байр ашиглалтын тогтмол зардлыг тухайн орон нутаг нь хариуцахаар орон нутгийн төсөвт тусгуулахаар боловсруулав.

ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ

4.1 Хууль эрх зүйн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал

Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын тогтоолууд, Монгол Улсын Засгийн Газрын тогтоол, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолууд, Эрүүл мэндийн сайдын тушаалуудыг үндэслэл болгон төсвийн төслийг боловсруулав.

4.1.1 2025 онд баримтлах төсвийн бодлого

- ✓ Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллана.
 - Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий Газар нь стратегийн худалдан авагчийн хувьд гэрээт эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоно;
 - Эмнэлзүйн хувьд үр дүн багатай хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ болон давхардсан оношилгоо, шинжилгээг бууруулна;
 - Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа болон чөлөөт өрсөлдөөнийг дэмжинэ;
 - Сангийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана;
 - Тусламж, үйлчилгээний үнэ тогтоох үйл явцыг өртгийн тооцоонд үндэслэн хэрэгжүүлнэ.
- ✓ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - Даатгуулагчийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэнэ;
 - Эрүүл мэндийн байгууллагуудад тусламж, үйлчилгээний чанарыг эрхэмлэх гэрээлэлт хийж, хэрэгжилтийг хангаж буйд тогтмол хяналт тавина;
 - Даатгуулагчдад эрүүл мэндийн салбарын хууль эрх зүй, санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна;
 - Олон улсын эмнэлзүйн удирдамжийн UpToDate платформын ашиглалтыг сайжруулна;
- ✓ Даатгуулагчдыг өвчлөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.
 - Урьдчилан сэргийлэх үзлэгийн багц үзлэгт хамрагдах даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ;
- ✓ Даатгуулагчийг санхүүгийн эрсдэлд орохоос хамгаална.

- Эмийн үнийн хөнгөлөлтийн хувь хэмжээг өөрчлөх, нэг эх үүсвэрийн худалдан авалтын тогтолцоог хэрэгжүүлэх замаар хямд, чанартай эмээр даатгуулагчийг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ

4.1.2 Эрүүл мэндийн даатгалын орлого бүрдүүлэлт, шимтгэлийн хувь

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх шимтгэлийн хувь, хэмжээг тооцохдоо “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхтэй уялдуулан шимтгэл ногдуулах хувь хэмжээг нэмэгдүүлж дараах байдлаар тооцов.

- Хөдөлмөр, нийгмийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 660,000 төгрөгөөр тооцсон.
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.1-д заасан ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар тооцсон.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын шимтгэлийн хэмжээг (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660 000 төгрөг) 4 хувиар тооцсон.
- 0-18 насны хүүхдийн шимтгэлийн хэмжээг (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660 000 төгрөг) 4 хувиар тооцсон.
- Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660 000 төгрөг) 4 хувиар тооцсон.

4.1.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тооцооллын зарчим

✓ Орлогын тооцоолол


- Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх, ажиллагсдаас төлөх, төсөвт байгууллагаас төлөх, сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогыг тооцохдоо 2022-2024 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд үндэслэн тооцов.
- Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 428 дугаар тогтоолыг үндэслэн тооцов;
- Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг

- 0-18 насны хүүхдийн тоон мэдээг - Үндэсний Статистикийн Хорооны “Статистикийн нэгдсэн мэдээллийн сан – 1212.mn”-аас, мөн Эрүүл мэндийн даатгалын цахим системээс
- Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, хүүхдээ 2 /ихэр бол 3 / нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтаны тоог Эрүүл мэндийн даатгалын цахим системд бүртгэгдсэн 2023 оны жилийн эцсийн статистик мэдээлэлд үндэслэн тооцоолсон.
- Улсын төсвөөс төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шилжүүлгийн зардлын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-д заасан тусламж, үйлчилгээ бүрээр гүйцэтгэлийг гаргаж, 2025 оны шилжүүлгийн хэмжээг тооцоолов.

✓ Шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөх хэрэгцээ, шаардлага:


1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр, тухайн даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан зардлын эзлэх хувиар харьцуулан гаргахад 2023 оны байдлаар ажил олгогчийн орлогоос шимтгэл төлж буй даатгуулагч нь нийт даатгуулагчийн 24 хувийг эзэлж байгаа бөгөөд даатгалын сангийн орлогын 69.2 хувийг бүрдүүлж, сангийн зардлыг 13.7 хувийг хүртсэн байна. Гэтэл төр хариуцах иргэд нь нийт даатгуулагчийн 71 хувийг эзэлж, даатгалын сангийн орлогын 27.4 хувийг бүрдүүлж, сангийн зардлын 77 хувийг хэрэглэж байна. Энэ нь хэдийгээр “эв санааны зарчим”-д суурилж байгаа ч цаашид тэнцвэрт байдлыг хангах чухал байна.

График 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр, болон даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан зардлын эзлэх хувь



2. Төр шимтгэлийг нь хариуцах иргэдэд 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч болон ял эдэлж байгаа ялтан хамаардаг, нийт 2,2 сая гаруй иргэний шимтгэлийг төрөөс хариуцдаг. Төрөөс олгож буй шимтгэлийн орлого болон эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулж буй зардлын гүйцэтгэлийг харьцуулан үзвэл 2023 онд тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд 82.1 тэрбум төгрөгийн орлогыг, 678.4 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээг зардлын гүйцэтгэлтэй байгаа бөгөөд зардал нь бүрдүүлж буй орлогоос 8.3 дахин их байна.

График 2. Төрөөс олгож буй шимтгэлийн орлого, ЭМДСангаас зарцуулж буй зардлын гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/




3. Бусад даатгуулагч болох хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого болон тусламж, үйлчилгээний зардлын гүйцэтгэлийг харьцуулан үзвэл 2023 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн шимтгэлийн орлого 21.9 тэрбум төгрөг, 100.1 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээг зардлын гүйцэтгэлтэй байгаа бөгөөд зардал нь бүрдүүлж буй орлогоос 4.6 дахин их байна.

График 3. Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулж буй зардлын гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



4. Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлого болон тусламж, үйлчилгээний зардлын гүйцэтгэлийг харьцуулан үзвэл 2023 онд 616.1 тэрбум төгрөг шимтгэлийн орлогыг бүрдүүлсэн бөгөөд 192.2 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээг зардлын гүйцэтгэлтэй байна.

График 4. Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлого, ЭМДСангаас зарцуулж зардлын гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



Иймд “эв санааны зарчим”-д суурилж байгаа ч цаашид тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.2, 8.1.3-т заалтад үндэслэн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

✓ Зарлагын тооцоолол

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу иргэн, даатгуулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг худалдан авах ба тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нийт болон эрүүл мэндийн байгууллага тус бүрээр тооцоолж төлөвлөсөн. Бүс нутгийн эрэлт хэрэгцээ, тусламж, үйлчилгээний

төвлөрлийг сааруулах бодлогыг дэмжиж зарим нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг дэмжсэн.

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ, оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жин, журмыг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, 2024 оны 04 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байна. Тус тогтоолын хүрээнд сангийн алдагдлыг бууруулах, оновчтой тусламж, үйлчилгээг дэмжих, шаардлагагүй тусламж, үйлчилгээг хязгаарлах өөрчлөлтүүд орсон. Суурь тарифын нэмэгдлийн зөрүү, төлбөрийг төр хариуцах эмийн төсвийн нөлөөллийг тооцож тусгав.
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлж, Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2024 оны 05 дугаар тогтоолоор батлан гаргаж 2024 оны 4 сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой орон нутгийн нэмэгдэл, шинэ багцтай холбоотой төсвийг төлөвлөв.
- Мөн эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг тооцоолохдоо шаардлагагүй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг бууруулах, амбулаторийн тусламж, үйлчилгээ болон эмийн үнийн хөнгөлөлтийн тусламж, үйлчилгээ нэмэгдүүлэх, иргэн, даатгуулагчид эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор дараах өөрчлөлтүүдийг тусгасан.
 - Хамтын төлбөрийн дээд хязгаарыг тогтоож, санхүүгийн эрсдэлтэй иргэнээс төлөх хамтын төлбөрийг хувьчилж бууруулах тохируулга
 - Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор алслагдсан бүс нутагт эмийн нөөцийг бүрдүүлэхэд хөшүүрэг болгож бүсийн коэффициентээр санхүүжүүлэх
- Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгооны төлбөрийн хэмжээг Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2023 оны 10 дугаар тогтоолоор 28-50 хувиар нэмэгдүүлэн батлуулж 2024 оны 2 дугаар сарын 13-наас хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой тооцоолол.
- ЭМДҮЗ, ЭМДЕГ-ын үйл ажиллагааны зардлыг ажиллах бүтэц, орон тоо, үйл ажиллагааны хамрах хүрээнд уялдуулан тооцсон.
- Эрсдэлийн сангийн хөрөнгийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20.2 дахь заалтын дагуу "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна." гэж заасны дагуу мөн МУ-ын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу тооцоолов.
- **Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1.13-т заасан "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад энэ хуулийн 20.1.3-т заасан урамшуулал олгох журмыг батлах" гэсэн заалтын дагуу тус тус төсөвлөв.**

4.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН 2024 ОНЫ ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

✓ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны орлого, хүлээгдэж буй гүйцэтгэл:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэл болон цалингийн сангийн мэдээлэлд үндэслэн тооцоход 1,967.4 тэрбум төгрөг гарч, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллана.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл /сая төгрөгөөр/

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН		2024 он		
		Төлөвлөгөө	ХБГ	Зөрүү
А. ОРЛОГО		1,964,757.3	1,967,434.5	(2,677.2)
1	Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл	859,154.7	859,154.7	-
2	Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	324,113.0	324,113.0	-
3	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	34,684.8	34,684.8	-
4	Бусад орлого	-	2,677.2	(2,677.2)
5	Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө	746,804.8	746,804.8	-

✓ Орлого хамралтын чиглэлээр 2024 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Эрүүл мэндийн сангийн 2024 оны орлого, хамралтын төлөвлөгөөг ЭМДЕГ-н даргын 2024 оны 01 сарын 22-ны өдрийн А/14, А/15 дугаар тушаалуудаар батлуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон орон нутгийн даатгалын хэлтэст хүргүүлж, орлого хамралтын явцад хяналт тавьж хамтран ажиллаж байна.
- Орон нутгийн даатгалын хэлтсүүдэд орлого хамралтын сар бүрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг даатгуулагчийн төрлөөр, аймаг, сумаар нь нарийвчлан гаргаж эргэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлж ажиллалаа.
- Мөн хамралт хангалтгүй байгаа малчдын асуудлаар аймгийн Засаг дарга нартай ЭМСайдын байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгайлан заалт оруулж ажилласан.
- Оюутнуудын шимтгэл төлөлтийн асуудлаар ЭМЯ-наас Боловсролын яамтай хамтран ажиллаж Засгийн газрын хуралдаанаар асуудлыг оруулж 998 оюутны 44,3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг шийдүүлж, шимтгэлийн ногдуулалтыг хийж ажиллалаа.

✓ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны зарлага, хүлээгдэж буй гүйцэтгэл:

Эрүүл мэндийн даатгалын 2024 оны төсвийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэлийг эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж буй 2023 оны тусламж, үйлчилгээний тоо хэмжээгээр

гэрээлэхээр тооцоход батлагдсан төсвөөс 455.1 тэрбум төгрөгөөр давахаар байсан. Иймд эрүүл мэндийн даатгалын байгууллага сангийн зарлагыг үр ашигтай зарцуулах, зарлагыг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

- 2024 онд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудтай хийх гэрээнд тусгайлсан бодлогыг хэрэгжүүлсэн. Тухайлбал өвчний амь нас аврах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ, бүс нутгийн хувьд эрэлт хэрэгцээтэй тусламж, үйлчилгээ, төрийн эрүүл мэндийн байгууллагуудад хүлээгдэл ихтэй тусламж, үйлчилгээ гэх мэтээр оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад буй тусламж, үйлчилгээг эрэмбэлж, тоо хэмжээ бүхий иж бүрэн гэрээ байгуулсан.
- ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад буй тусламж, үйлчилгээнээс нийт төрийн болон орон нутгийн 39 эрүүл мэндийн байгууллагын 457,000 гаруй өвчний түүхэнд өртөгийн судалгаа хийж, холбогдох арга хэмжээний саналыг боловсруулж ажилласан.
- 2022, 2023 оны гүйцэтгэлээр нэхэмжлэлийн тоо хэмжээ хэт өсөлттэй тусламж, үйлчилгээ бүрийг хянаж оношийн хамааралтай бүлгийн багцыг шинэчилж ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 болон 06 дугаар тогтоолуудаар батлуулж 2024 оны 4 сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн.
- Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээний 2022 оноос хойших нэхэмжлэл, олгохоор тооцсон мөнгөн дүн, холбогдох үр дүнг нэгтгэж харуулсан дашбоардыг угсарч шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах, дотоод хяналтыг тавих нөхцлийг бүрдүүлж ажиллалаа.

Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Тусламж, үйлчилгээний төрөл	2023 оны гүйцэтгэл	2024 он		
			Батлагдсан төсөв	ХБГ	Зөрүү
1	Лавлагаа шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ	1,272,839	1,205,480	1,243,186	(37,706)
1.1	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	226,875.5	184,946.5	233,755.5	(48,809)
1.2	Диализын тусламж, үйлчилгээ	31,466.1	33,956.4	32,976.3	980
1.3	Өдрийн эмчилгээ	51,048.9	50,868.3	49,501.8	1,366
1.4	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	52,046.1	33,353.3	11,561.2	21,792
1.5	Сувиллын тусламж, үйлчилгээ	-	-	30,871.9	(30,872)
1.6	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	52,600.0	46,025.2	29,882.3	16,143
1.7	Телемедициний тусламж, үйлчилгээ	38.8	41.0	39.9	1
1.8	Түргэн тусламж	28,028.0	30,442.1	30,108.5	334

1.9	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	56,573.9	50,103.8	34,935.3	15,169
1.1	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	6,994.7	7,734.8	7,733.5	1
1.11.	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	689,476.3	684,879.3	672,504.0	12,375
1.12	Яаралтай тусламж, үйлчилгээ	66,342.6	71,751.9	71,068.4	684
1.13.	Төлбөрийг төр хариуцах эм	11,348.3	11,377.0	38,247.5	(26,870)
2	Анхан шат тусламж, үйлчилгээ	358,804.3	455,048.5	489,606.9	(34,558)
2.1.	Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээ	272,430.7	359,383.0	351,302.6	8,080
2.2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	50,239.6	61,947.9	80,878.7	(18,930.8)
2.3.	ӨСТЭМТ-өөс үзүүлэх 4 тусламж, үйлчилгээ	36,134.1	33,717.6	57,425.6	(23,708)
3	Эмийн үнийн хөнгөлөлт	95,684.6	137,322.8	137,322.8	-
4	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	42,609.0	62,841.1	44,207.5	18,634
4	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн зардал		53,562.6		53,563
5	Өмнөх оны өглөг	60,581.1		218,317.3	(218,317)
6	Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардал	10,285.8	16,445.8	16,445.8	-
7	ЭМД-ын шимтгэлийн илүү төлөлтийн буцаалт	313.9	470.9	470.9	-
8	ЭМД-ын тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан даатгалын гэрээтэй ЭМБ-д олгох урамшууллын зардал;		2,000.0	2,000.0	
Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлага		1,841,118	1,933,172	2,151,557	(218,385.7)
Үүнээс олгосон		1,622,800.8	1,933,171.6	1,933,171.6	-
Өглөг		218,317.3	-	218,385.7	

✓ Сангийн нийт зарлага **2024** оны төсвийн тухай хуулиар сангийн зарлагыг 1,933.1 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ оны зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэлийн тооцооллоор 2,151.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй буюу батлагдсан төсвөөс 218.3 тэрбум төгрөг дутахаар байна. Үүнд 2022 оны өглөг болох 60.6 тэрбум төгрөг багтаж байгаа болно.

4.3 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

4.3.1 Сангийн 2025 оны төсвийн тэнцэл

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөлд сангийн орлогыг 2,727,1 тэрбум төгрөгөөр, сангийн зарлагыг 2,475.6 тэрбум төгрөгөөр, сангийн тэнцэл 17.1 тэрбум төгрөгийн ашигтай байхаар тус тус төлөвлөв. Энэ нь 2024 оны батлагдсан төсвөөс орлого 527.9 тэрбум төгрөгөөр (27.3%), зарлага 542.4 тэрбум төгрөгөөр (25.2%) нэмэгдэж байна.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл /сая төгрөгөөр/

	САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2023 он	2024 он		2025 он
		Гүйцэтгэл	Батлагдсан	ХБГ	Төсөл
1	А. ОРЛОГО	1,608,714.9	1,964,757.3	1,967,434.5	2,881,699.1
2	Б. ЗАРЛАГА	1,841,118.1	1,933,171.5	2,151,566.4	2,787,280.0
3	В. САНГИЙН ТЭНЦЭЛ	218,317.3		218,317.3	94,419.1

4.3.2 Сангийн орлого

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөлд нийт 2,881.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 32,8 хувь буюу 945.1 тэрбум төгрөгийг ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлогоос, 24,5 хувь буюу 706,1 тэрбум төгрөгийг төр хариуцах иргэдийн шимтгэлийн орлогоос, 3,5 хувь буюу 64,9 тэрбум төгрөгийг шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлогоос, 38,8 хувь буюу 1,119.4 тэрбум төгрөгийг төр хариуцах тусламж, үйлчилгээний улсын төсвийн орлогоос, 0,4 хувь буюу 11.4 тэрбум төгрөгийг бусад орлогоос бүрдүүлэхээр тус тус төлөвлөв.

- ✓ Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн шимтгэлийн орлогыг жилийн орлогын дундаж өсөлтөөр тооцон 2024 оны батлагдсан төсвөөс 85.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 945.1 тэрбум төгрөгөөр төлөвлөв.
- ✓ Төр шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлийн орлогыг Монгол Улсын Засгийн үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу төр хариуцах иргэдийн шимтгэлийн хувийг тус тус 4 хувиар тооцон 2024 оны батлагдсан төсвөөс 381,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 706,1 тэрбум төгрөгөөр төлөвлөв.
- ✓ Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн жилийн дундаж өсөлтөөр тооцон, үүнээс гадна 2025 онд 4%-иар нэмэгдүүлж, 2024 оны батлагдсан төсвөөс 64,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцоолов.
- ✓ Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох санхүүжилтийг 2023 оны гүйцэтгэл болон 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлд үндэслэн энэ оны

батлагдсан төсвөөс 372,6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 1,119.4 тэрбум төгрөгөөр төлөвлөв.

- ✓ ЭМД-ын тухай хуулийн 20.5 дагуу Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан, түүнийг төрийн санд хадгалуулснаас олсон орлогыг Монгол банкны бодлогын

хүүгийн түвшнээр тооцож 10 сар хадгалахаар тооцож, 11.4 тэрбум төгрөг байхаар тооцов. /Монгол банкны 2024 оны 05 дугаар сарын мэдээгээр бодлогын хүү 11 хувь байна.

Хүснэгт 4. Сангийн нийт орлого /сая төгрөгөөр/

Төсвийн үзүүлэлт	2024 он		2025 он	
	Батлагдсан төсөв	ХБГ	Төсвийн төсөл	Зөрүү (2025-2024)
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ - А. ОРЛОГО	1,964,757.3	1,934,757.3	2,881,699.1	916,941.8
1. Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл	859,154.7	829,154.7	945,070.2	85,915.5
2. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	324,113.0	324,113.0	706,073.4	381,960.4
3. Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	34,684.8	34,684.8	99,633.1	64,948.3
4. Бусад орлого	-	-	11,429.9	11,429.9
5. Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө	746,804.8	746,804.8	1,119,492.5	372,687.7

4.3.3 Сангийн зарлага

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөлд нийт 2,787.3 тэрбум төгрөгийн зарлагаас 87.7 хувь буюу 2,445.4 тэрбум төгрөгийн эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж, үйлчилгээний зардалд, 7,1 хувь буюу 197.3 тэрбум төгрөгийг эмийн хөнгөлөлтийн зардалд, 0.7 хувь буюу 19,8 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 4.5 хувь буюу 124.7 тэрбум төгрөгийг эрсдэлийн сангийн зардал тус тус зарцуулахаар төлөвлөв.

- ✓ Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас 2024 оны батлагдсан төсөвт багтаан (өмнөх оны өглөг ороогүй), зардлыг үр ашигтай зарцуулах зорилгоор худалдан авах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тоо хэмжээг 2023 оны гүйцэтгэлийн тоо хэмжээнээс нэмэгдүүлэлгүй, зарим тусламж, үйлчилгээний тоо хэмжээг бууруулан, гэрээ байгуулан ажиллаж байгаа билээ. 2025 онд өмнөх оны өглөгийг бүрэн олгохоор төлөвлөсөнтэй холбоотойгоор мөнгөн урсгалын тооцооллыг хийж, зарим тусламж, үйлчилгээний өртгийг нарийвчлан тооцох, мөн зарим тусламж, үйлчилгээг анхан шатны тусламж, үйлчилгээрүү шилжүүлэх замаар тохиолдлын тоог 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс хэтрүүлэхгүй байхаар тооцож, тарифыг инфляцийн түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлэхээр тооцов. Төр хариуцах эмийн төсвийг 2024 оны 06 дугаар тогтоолын хүрээнд тооцов. Уг тогтоолоор 2024 оны 4 дүгээр сараас эхлэн хавдрын химийн бай эмчилгээ, дархлаа дарангуйлах, уналт таталтын эмийг

олгох болсонтой холбоотой 2024 оны батлагдсан төсвөөс 26.18 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Мөн 2025 онд нэмэгдэж Төр хариуцах эмийн жагсаалтад Засгийн газрын тогтоолоор элэгний в, д вирусын эм орохоор (20 тэрбум төгрөг) төлөвлөгдсөн учир уг эмийн төсвийг тооцож орууллаа.

- ✓ Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05 дугаар тогтоол, 2023 оны жилийн эцсийн Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо, сүүлийн 3 жилийн хүн амын дундаж цэвэр өсөлтийн статистик мэдээлэлд тус тус үндэслэн төлөвлөв. Өрх, сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээнд 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хүүхдийн өдрийн эмчилгээг /ханиад томуугийн эмийн багц/, 2.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцов. СТЭМТ-өөс үзүүлэх үндсэн тусламж, үйлчилгээний төсвийг энэ жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээс нэмэгдүүлэхгүй байхаар тооцов.
- ✓ 2025 онд хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээг бууруулж эмийн үнийн хөнгөлөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ нь гүйцэтгэлийн санхүүжилтийн бодлогын чухал хэсэг бөгөөд амбулаторийн тусламж, үйлчилгээг дэмжиж, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлэгт хэвтэлтийг бууруулахад чухал үүрэгтэй. Мөн ДЭМБ-ын хийсэн судалгаанаас үзвэл хувь хүний халааснаасаа эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа төлж буй төлбөрийн 68 хувийг эмийн зардал эзэлж байна. ЭМД-ын хөнгөлөлт, хүртээмж сайжирсан хэдий ч хязгаарлагдмал өвчнүүд дээр хөнгөлөлт хийж буй учраас хөнгөлөлтөнд ороогүй эмүүдийг иргэд халааснаасаа төлсөн хэвээр байна. Иймд аль болох иргэд эмнэлэг хэвтэхгүй амбулаториор эмчлэх, амбулаториор эмчлүүлж байхдаа хөнгөлөлттэй эмээ хүртээмжтэй авах, халааснаас аль болох бага зардал гаргах үүднээс хөнгөлөлттэй эмийн төсвийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн шинэчлэлийг сайжруулах хүрээнд ахмадуудын хувьд хөнгөлөлттэй эмийн хамтын төлбөрт тэтгэврийнхээ дийлэнх хэсгийг зарцуулж байгаа тул хувиар биш, тогтмол мөнгөн дүнгээр хамтын төлбөр төлдөг, урт хугацааны хүнд өвчтэй хүнд аль болох хамтын төлбөрийн дарамт бага байлгах бодлого баримталж, өөрчлөлтийг хийхээр төлөвлөж 2025 оны төсвийн төсөлд тусгав.
- ✓ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эрт илрүүлгийг 2025 онд үргэлжлүүлнэ гэж үзэж, зардлыг ЭМДҮЗ-н 2023 оны 10 дугаар тогтоолоор, 2024 оны батлагдсан төсвөөр тооцов.
- ✓ ЭМД-ын тухай хуульд заасны дагуу сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувиар эрсдэлийн санг байгуулахаар хуульчилсан. 2024 оны ХБГ ээс үзвэл өмнөх оны өглөг болон тусламж, үйлчилгээ тоо, хэмжээнээс өсөлтөөс шалтгаалж эрсдэлийн сан нь бүрэн зарцуулагдахаар байна. 2025 оны эрсдэлийн сангийн хөрөнгийн хэмжээг МУЗГ-н үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу, 2025 оны эрүүл мэндийн даатгалын орлогын 5 хувиар тооцон төлөвлөв.

- ✓ Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг нэхэмжлэлийн хяналтын хүрээг мэргэжлийн эмч шинжээч нарын оролцоотойгоор өргөжүүлж олон улсад хийдэг жишигт хүргэх, Uptodate олон улсын эмнэлзүйн удирдамжийг үргэлжлүүлэх, ЭМД-ын цахим системийг өргөжүүлэх, нэхэмжлэлийн цахим хяналтыг бий болгож, цахим системийг өргөжүүлэх, тусламж, үйлчилгээний өртгийн нарийвчилсан тооцооллыг хийх, ЭМД-н албан хаагчдын цалингийн өсөлттэй, ажлын үр дүнд уялдсан бүтээмжийн урамшуулал олгох, мөн бусад зардлыг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэв.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1.13-т заасан "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад энэ хуулийн 20.1.3-т заасан урамшуулал олгох журмыг батлах" гэсэн заалтын дагуу 5 тэрбум төгрөгөөр төсөвлөв.

Хүснэгт 5. Сангийн нийт зарлага /сая төгрөгөөр/

№	Тусламж, үйлчилгээний төрөл	2024 оны батлагдсан төсөв	2024 оны ХБГ	2025 оны төсвийн төсөл
		Мөнгөн дүн	Мөнгөн дүн	Мөнгөн дүн
1	Лавлагаа шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ	1,205,480	1,243,186	1,342,866
1.1	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	184,946.5	233,755.5	247,780.9
1.2	Диализын тусламж, үйлчилгээ	33,956.4	32,976.3	34,954.8
1.3	Өдрийн эмчилгээ	50,868.3	49,501.8	52,471.9
1.4	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	33,353.3	11,561.2	12,254.9
1.5	Сувиллын тусламж, үйлчилгээ	-	30,871.9	32,724.3
1.6	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	46,025.2	29,882.3	31,675.2
1.7	Телемедициний тусламж, үйлчилгээ	41.0	39.9	42.3
1.8	Түргэн тусламж	30,442.1	30,108.5	31,915.0
1.9	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	50,103.8	34,935.3	37,031.4
1.1	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	7,734.8	7,733.5	8,197.6
1.11.	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	684,879.3	672,504.0	712,854.2
1.12	Яаралтай	71,751.9	71,068.4	75,332.5
1.13.	Төр хариуцах эм	11,377.0	38,247.5	65,630.9
2	Анхан шат тусламж, үйлчилгээ	455,048.5	489,606.9	723,659.6
2.1.	Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээ	359,383.0	351,302.6	583,102.6
2.2.	Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ	7,670.6	80,878.7	7,670.6

2.3.	Яаралтай тусламж	6,099.5		8,843.4
2.4.	Түргэн тусламж	14,278.8		22,007.3
2.5.	Хэвтүүлэн эмчлэх	33,899.0		42,357.4
2.6.	ӨСТЭМТ-өөс үзүүлэх 4 тусламж, үйлчилгээ	33,717.6	57,425.6	59,678.4
3	Эмийн үнийн хөнгөлөлт	137,322.8	137,322.8	197,322.8
4	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	62,841.1	44,207.5	62,840.8
5	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн зардал	53,562.6		124,690.4
6	Өмнөх оны өглөг		218,317.3	218,317.3
7	Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардал	16,445.8	16,445.8	19,818.3
8	Нийгмийн даатгалын байгууллагад олгох орлого цуглуулах үйл ажиллагааны зардал			500,0
9	ЭМД-ын шимтгэлийн илүү төлөлтийн буцаалт	470.9	470.9	480.0
10	ЭМД-ын тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан даатгалын гэрээтэй ЭМБ-д олгох урамшууллын зардал;	2,000.0	2,000.0	5,000.0
11	Суурь тарифын өсөлт, тогтоол хоорондын зөрүү			91,784.800
Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлага		1,933,172	2,151,557	2,787,280.0
Үүнээс олгосон		1,933,171.6	1,933,171.6	
Өглөг		-	218,385.7	

4.4 Үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй

4.4.1 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын 2025 оны төсвийн төслийг 2024 оны батлагдсан төсвөөс 2.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 18.3 тэрбум төгрөгөөр төлөвлөв.

- ✓ Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2024 оны батлагдсан төсвөөс 22.1 хувь буюу 1.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөв. Үндсэн цалинг Засгийн Газрын 2024 оны 128 дүгээр тогтоолын зөрүүгээр нэмэгдүүлсэн ба орон нутагт ажиллаж буй ажилтан албан хаагчдын нэмэгдлийг тусгасан. Мөн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 18.4-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч, мэргэжилтэнд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт хангасан байдал, ажлын үр дүнг үндэслэн бүтээмжийн урамшуулал олгох бөгөөд холбогдох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэсэн заалтын дагуу ЭМСайдын 2022 оны А/614 тушаалын дагуу

ЭМДЕГ-ын албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг жилд 2 удаа олгохоор баталсны дагуу үндэслэн төлөвлөсөн.

- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2.3 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд, тусламж, үйлчилгээ авсан 1.0 сая тохиолдолд мессеж үйлчилгээг явуулахаар тооцоолов. Түүнчлэн мэдээллийн технологийн төсвийг нэмэгдүүлэх замаар хиймэл оюун ухаанд суурилсан хяналт, эрсдэлийн илрүүлгийг ЭМД-ын хяналтад нэвтрүүлэх, холбогдох програм хангамжийн хөгжүүлэлтэд шаардлагатай зардлыг оруулж тооцлоо. Түүнчлэн Uptodate олон улсын эмнэлзүйн удирдамжийн платформын гэрээг үргэлжлүүлэхээр тооцоолсон. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын гол чиг үүрэг болох нэхэмжлэлийн хяналтын үйл ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлэх нь тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой юм. Үүний хүрээнд сар бүр эмнэлгийн тусламж, үйлчилгээний 900 мянган нэхэмжлэлийн ердөө 15 орчим хувийг л түүвэрлэн хянаж байна. Гэвч эмнэлгүүдийн нэхэмжлэлийн тоо хэмжээ 2022 онтой харьцуулахад дунджаар сар бүр 150-200 мянган тохиолдлоор нэмэгдэж байгаа учраас дээрх нэхэмжлэлийг хянах цаг хүрээг өргөжүүлэхгүй бол хуурамч нэхэмжлэл, чанаргүй нэхэмжлэлд санхүүжилт олгох бодит эрсдэл байна. Иймд ЭМД-ын тухай хуулинд заасны дагуу нэхэмжлэлийн хяналтыг мэргэжлийн шинжээчдийг сонгон шалгаруулж, гэрээт хэлбэрээр тогтмол ажиллуулах олон улсын туршлагуудаас үүдэж зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, мөн тусламж, үйлчилгээний өртгийг гэрээгээр эрүүл мэндийн байгууллага бүрээр нарийвчилсан тооцохоор тусгав.

Хүснэгт 6. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны 2025 оны төсвийн төсөл /мян.төгрөгөөр/

Зардлын зүйл	Мөрийн дугаар	2024 оны төсөв	2025 оны төсөв	Зөрүү
1. Урсгал зардал /2+42/	1	16,046,566.9	18,340,636.4	2,294,069.5
1.1 Бараа, ажил, үйлчилгээний зардал /3+8+14+19+24+27+29+39/	2	15,286,497.5	17,768,806.9	2,482,309.4
1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил /4+5+6+7/	3	8,244,615.6	10,067,403.6	1,822,788.0
1.1.1.1 Үндсэн цалин хөлс	4	4,825,352.5	5,414,045.5	588,693.0
1.1.1.2 Нэмэгдэл	5	1,782,045.2	1,999,454.7	217,409.5
1.1.1.3 Унаа хоолны хөнгөлөлт	6	676,595.7	826,799.9	150,204.2
1.1.1.4 Урамшуулал	7	960,622.2	1,827,103.4	866,481.2

1.1.2 Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл /9+10+11+12+13/	8	1,030,576.7	1,166,200.6	135,623.9
1.1.2.1 Тэтгэврийн даатгал	9	700,792.4	786,289.1	85,496.7
1.1.2.2 Тэтгэмжийн даатгал	10	82,446.1	94,977.9	12,531.8
1.1.2.3 ҮОМШ өвчний даатгал	11	65,956.8	47,488.8	18,468.0
1.1.2.4 Ажилгүйдлийн даатгал	12	16,489.1	47,488.9	30,999.8
1.1.2.5 Эрүүл мэндийн даатгал	13	164,892.3	189,955.9	25,063.6
1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал /15+16+17+18/	14	161,865.0	201,232.5	39,367.5
1.1.3.1 Гэрэл цахилгаан	15	49,050.0	55,034.1	5,984.1
1.1.3.2 Түлш, халаалт	16	39,240.0	44,027.3	4,787.3
1.1.3.3 Цэвэр, бохир ус	17	24,525.0	27,517.1	2,992.1
1.1.3.4 Байрны түрээс	18	49,050.0	74,654.1	25,604.1
1.1.4 Хангамж, бараа материалын зардал /20+21+22+23/	19	236,380.2	255,763.4	19,383.2
1.1.4.1 Бичиг хэрэг	20	59,806.7	64,710.8	4,904.1
1.1.4.2 Тээвэр шатахуун	21	18,946.4	20,500.0	1,553.6
1.1.4.3 Шуудан холбоо интернэтийн төлбөр	22	78,480.0	84,915.4	6,435.4
1.1.4.4 Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс худалдан авах	23	79,147.1	85,637.2	6,490.1
1.1.5 Эд хогшил, урсгал засварын зардал /25+26/	24	68,670.0	85,204.5	16,534.5
1.1.5.1 Багаж, техник, хэрэгсэл	25	29,430.0	40,000.0	10,570.0
1.1.5.2 Урсгал засвар	27	39,240.0	45,204.5	5,964.5
1.1.6 Томилолт, зочны зардал /28/	28	127,530.0	148,189.9	20,659.9
1.1.6.1 Дотоод албан томилолт	29	127,530.0	148,189.9	20,659.9
1.1.7 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж /30+31+32+33+34+35+36+37+38/	30	4,721,801.0	5,092,758.7	370,957.7
1.1.7.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31	2,162,945.7	2,324,077.2	161,131.5
1.1.7.2 Даатгалын үйлчилгээ	33	1,962.0	2,122.9	160.9

1.1.7.3 Тээврийн хэрэгслийн татвар	34	1,962.0	2,122.9	160.9
1.1.7.4 Тээврийн хэрэгслийн оношилгоо	35	467.3	505.6	38.3
1.1.7.5 Газрын төлбөр	36	921.0	996.5	75.5
1.1.7.6 Мэдээлэл технологийн үйлчилгээ	37	2,550,600.0	2,759,749.2	209,149.2
1.1.7.7 Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	38	2,943.0	3,184.3	241.3
1.1.8 Бараа үйлчилгээний бусад зардал /40+41/	40	695,059.0	752,053.8	56,994.8
1.1.8.1 Бараа үйлчилгээний бусад зардал	41	646,499.5	699,512.5	53,013.0
1.1.8.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага	42	48,559.5	52,541.4	3,981.9
1.2 Урсгал шилжүүлэг /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг/ /43+44/	43	760,069.4	571,829.4	188,240.0
1.2.1 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	44	414,369.7	496,155.1	81,785.4
1.2.2 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45	345,699.7	75,674.3	270,025.4
2. Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	46	16,046,566.9	18,340,636.4	2,294,069.5
3. Эрүүл мэндийн даатгалын сангаас	47	16,046,566.9	18,340,636.4	2,294,069.5
4. Ажиллагсадын тоо	48	285.0	285.0	-
Удирдах ажилтан	49	38.0	38.0	-
Гүйцэтгэх ажилтан	50	232.0	247.0	15.0
5. Орон тооны мэдээлэл	51	285.0	285.0	-
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	52	233.0	260.0	27.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	53	52.0	25.0	- 27.0
6.Нийт тэтгэвэрт гарагч	54	9.0	9.0	-
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	55	9.0	9.0	-

4.4.2 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардал

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлын 2025 оны төсвийн төслийг 2024 оны батлагдсан төсвөөс 732.6 сая нэмэгдүүлэн 1,477.6 сая төгрөгөөр

төлөвлөв. Эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн ажлын алба 2025 онд 18 орон тоогоор ажиллахаар төлөвлөсөн болно. Мөн дэргэдээ техникийн хороо байгуулагдсантай байгаатай холбоотойгоор үндэсний зөвлөлийн ажлын цар хүрээг нэмэгдүүлэх, төлөөллийн байгууллагуудтайгаа уулзалт хэлэлцүүлэг хийх, судалгаа хийх, даатгуулагчдын тулгамдсан асуудлыг илрүүлэх, тогтоолуудын хэрэгжилтэд хяналт тавих, техникийн хорооны гишүүдийн ажлын хөлс зэрэг зардлын өсөлтүүдийг тусгасан.

Хүснэгт 7. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны төсвийн төсөл

/мян.төгрөгөөр/

Зардлын зүйл	Мөрийн Дугаар	2024 оны төсөв	2025 он төсвийн төсөл	Зөрүү
1. Урсгал зардал /2+28/	1	744,972.5	1,477,653.9	732,681.4
1.1 Бараа, ажил, үйлчилгээний зардал /3+8+14+18+20+22+25/	2	717,896.9	1,326,538.5	608,641.6
1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил /4+5+6/	3	445,485.8	850,726.9	405,241.1
1.1.1.1 Үндсэн цалин хөлс	4	262,480.3	457,848.0	195,367.7
1.1.1.2 Нэмэгдэл	5	105,368.7	224,986.9	119,618.2
1.1.1.3 Унаа хоолны хөнгөлөлт	6	42,732.4	91,584.0	48,851.6
1.1.1.4 Урамшуулал	7	34,904.4	76,308.0	41,403.6
1.1.2 Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл /9+10+11+12+13/	8	55,685.6	106,340.9	50,655.3
1.1.2.1 Тэтгэврийн даатгал	9	37,866.2	72,311.8	34,445.6
1.1.2.2 Тэтгэмжийн даатгал	10	4,454.8	8,507.3	4,052.5
1.1.2.3 ҮОМШ өвчний даатгал	11	3,564.0	4,253.6	689.6
1.1.2.4 Ажилгүйдлийн даатгал	12	890.9	4,253.6	3,362.7
1.1.2.5 Эрүүл мэндийн даатгал	13	8,909.7	17,014.5	8,104.8
1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал /15/	14	63,584.5	101,873.8	38,289.3
1.1.3.1 Гэрэл, цахилгаан	15	2,386.0	5,886.0	3,500.0
1.1.3.2 Түлш, халаалт	16	1,905.0	4,905.0	3,000.0
1.1.3.3 Цэвэр, бохир ус	17	1,905.0	5,000.0	3,095.0
1.1.3.4 Байрны түрээс	18	57,388.5	86,082.8	28,694.3
1.1.3 Хангамж, бараа материалын зардал /17+18+19/	19	23,920.8	38,429.7	14,508.9
1.1.3.1 Бичиг хэрэг	20	6,619.8	9,929.7	3,309.9
1.1.3.2 Тээвэр шатахуун	21	2,943.0	4,500.0	1,557.0
1.1.3.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22	2,586.0	6,000.0	3,414.0
1.1.3.5 Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс худалдан авах	23	11,772.0	18,000.0	6,228.0
1.1.4 Эд хогшил, урсгал засварын зардал /21/	24	11,629.0	38,243.5	26,614.5
1.1.4.1 Багаж, техник, хэрэгсэл	25	11,629.0	13,243.5	1,614.5
1.1.4.2 Тавилга	26		25,000.0	25,000.0

1.1.5 Томилолт, зочны зардал /23/	28	22,612.0	33,918.0	11,306.0
1.1.5.1 Дотоод албан томилолт	29	22,612.0	33,918.0	11,306.0
1.1.6 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж /25+26+27/	30	79,121.3	81,484.9	2,363.6
1.1.6.1 Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	31	75,334.6	75,334.6	-
1.1.6.2 Мэдээлэл технологийн үйлчилгээ	35	3,433.5	5,150.3	1,716.8
1.1.6.3 Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	37	353.2	1,000.0	646.8
1.1.7 Бараа үйлчилгээний бусад зардал /29/	39	15,857.9	150,855.6	134,997.7
1.1.7.1 Бараа үйлчилгээний бусад зардал			77,695.2	77,695.2
1.1.7.2 Хичээл йлдвэрлэлийн дадлага хийх	40	15,857.9	73,160.4	57,302.5
1.2 Урсгал шилжүүлэг /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг/31/	41	27,075.6	151,115.4	124,039.8
1.2.1 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж			111,115.4	111,115.4
1.2.1 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42	27,075.6	40,000.0	12,924.4
2. Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	43	744,972.5	1,477,653.9	732,681.4
3. Эрүүл мэндийн даатгалын сангаас	44	744,972.5	1,477,653.9	732,681.4
4. Ажиллагсадын тоо	45	12.0	18.0	6.0
Удирдах ажилтан	46	1.0	1.0	-
Гүйцэтгэх ажилтан	47	11.0	17.0	6.0
5. Орон тооны мэдээлэл	48	12.0	18.0	6.0
Ажлын албаны албан хаагч (АА)	49	8.0	14.0	6.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	50	4.0	4.0	-

4.5 2026, 2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026-2027 оны Төсвийн төсөөллийг “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөв.

Хүснэгт 8. Төсвийн төсөөлөл /сая төгрөгөөр/

Төсвийн үзүүлэлт	2025 он	2026 он	2027 он
	Төсвийн төсөл	Төсвийн төсөөлөл	
А. ОРЛОГО	2,881,699.1	3,083,418.1	3,299,257.3
1. Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл	945,070.2	1,011,225.1	1,082,010.8
2. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	706,073.4	755,498.5	808,383.4
3. Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	99,633.1	106,607.4	114,069.9
4. Бусад орлого	11,429.9	12,230.0	13,086.1
5. Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө	1,119,492.5	1,197,857.0	1,281,707.0
Б. ЗАРЛАГА	2,787,280.0	2,982,389.6	3,191,156.9

1.	Эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж үйлчилгээний санхүүжилт	2,445,448.5	2,616,629.9	2,799,794.0
	1.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,325,956.0	1,418,772.9	1,518,087.0
	1.2 Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,119,492.5	1,197,857.0	1,281,707.0
2	Эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд	197,322.8	211,135.4	225,914.9
3	Үйл ажиллагааны урсгал зардал	19,818.3	21,205.6	22,690.0
4	Эрсдэлийн сан	124,690.4	133,418.7	142,758.0
С. САНГИЙН ТЭНЦЭЛ (ОРЛОГО-ЗАРЛАГА)		94,419.1	101,028.47	108,100.46

ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Эрүүл мэндийн салбарт 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам” болон Сангийн яамнаас ирүүлсэн “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсөөлөл бэлтгэх удирдамж”-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны хөрөнгө оруулалтын төсвийн төслийн саналыг нэгтгэн боловсрууллаа.

2025 онд төсвийн тухай хуулиар шилжин хэрэгжих, өмнөх онуудад болон 2023 онд санхүүжилт нь буцааны татагдсан төсөл, арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх, Улсын Их Хурлын болон Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдэд шаардагдах /УИХ-ын гишүүдээс ирүүлсэн саналыг тусгаснаар/ нийт 216 төсөл, арга хэмжээний **1,916.8 тэрбум** төгрөгийн төсөвт өртөг бүхий **945.5 тэрбум** төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт тусгуулахаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын (<https://pimis.publicinvestment.gov.mn/>) цахим системээр нэгтгэсэн.

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГУУЛАХ НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОВЧОО

№	Эдийн засгийн ангилал	2024 он		
		Тоо	Төсөвт өртөг /сая.төг/	Санхүүжих дүн /сая.төг/
1	Барилга байгууламж	126	1,553,152.59	599,375.95
1.1	Шилжих	44	388,724.4	150,910.9
1.2	Шинэ	82	1,164,428.19	448,465.05
2	Их засвар	41	162,002.17	146,027.71

2.1	Шилжих	2	5,053.71	2,287.51
2.2	Шинэ	39	156,948.46	143,740.2
3	Тоног төхөөрөмж	48	200,885.1	199,685.1
3.1	Шилжих	2	2,500.0	1,300.0
3.2	Шинэ	46	198,385.1	198,385.1
4	ТЭЗҮ, Зураг төсөв	1	800.0	400.0
	НИЙТ			

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Барилга байгууламжийн хөрөнгө оруулалтад нийт **1,553.15** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **599.4** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй **126** төсөл, арга хэмжээ санал нэгтгэгдсэнээс **шилжих** барилга байгууламжийн хөрөнгө оруулалтад **388.7** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **150.9** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй **44** төсөл арга, хэмжээ, **шинэ** барилга байгууламжийн хөрөнгө оруулалтад **1,164.4** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **448.5** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй **82** төсөл арга, хэмжээ нэгтгэгдсэн.

ИХ ЗАСВАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

